

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ****Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг  
зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 23, 59, 60, 61, 64, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Хувьцаа эзэмшигч А.Шагдарсүрэн, Ш.Баярсайхан нарын зүгээс 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр гаргасан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах санал шаардлага, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 11:40 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт байрлах “Номин Юнайтед” төвийн 4.5 дугаар давхрын “Улаанбаатар” хурлын өрөөнд зохион байгуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
  - 2.1. Компанийн хэлбэрийг өөрчилж, Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) болгох.
  - 2.2. ТУЗ-ийн өргөн барьсан Компанийн хэлбэрийг өөрчлөх төсөл, нөхцөл, журмыг батлах.
  - 2.3. ТУЗ-ийн өргөн барьсан Хувьцаа нэгтгэх, хөрвүүлэх журмыг батлах.
  - 2.4. ТУЗ-ийн өргөн барьсан Хувьцаа эргүүлэн худалдан авах журмыг батлах.
  - 2.5. Үнэт цаасны зах зээлд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдийн дүгнэлтийг батлах.
  - 2.6. Үнэт цаасны зах зээлд хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий хуулийн этгээдийн гаргасан компанийн хөрөнгийн үнэлгээний тайланг батлах.
  - 2.7. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах.
3. Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр, 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрүүдэд өдөр тутмын сонин хэвлэл болон телевизийн үгэн зараар хувьцаа эзэмшигчдэд хүргэхээр тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөр тасалбар болгосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, хурлын материал, санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт болон бусад баримт бичиг, шийдвэрийн төсөлтэй хувьцаа эзэмшигчид 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс хойш Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт байрлах “Номин юнайтед” төвийн 5 дугаар давхарт ТУЗ-ийн нарийн бичгийн дарга дээр Даваагаас Баасан гарагуудад ажлын цагаар танилцах боломжтой болохыг мэдээлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал авах хуудсыг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн ирж оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөр тасалбар болгож, брокер дилерийн компани болон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт буюу “Номин юнайтед” цогцолборын 5 дугаар давхарт тус тус хүлээж авахаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар ТУЗ-ийн дарга А.Шагдарсүрэнг томилсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргын эрх, үүргийг хүчин төгөлдөр итгэмжлэлийн дагуу өөр этгээдэд шилжүүлэх эрхийг А.Шагдарсүрэнд олгосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын гишүүдээр Эдийн засагч Өлзийсайханы Оюун-Эрдэнэ, Эрх зүйч Энхболдын Төгсжаргал, Эрх зүйч Батмөнхийн Сансар нарыг томилсугай.
11. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх Ч.Үржинбадам, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарыг томилж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, зохион байгуулах бэлтгэлийг хангаж ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



А.ШАГДАРСҮРЭН

2022 оны 12 дугаар  
сарын 16 -ны өдөр

№: 22/19

Улаанбаатар  
хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хөрөнгө актлах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан “Хөвсгөл усан зам” ХК-ийн балансад бүртгэлтэй, элэгдэж дууссан буюу үлдэх өртөггүй болсон хөрөнгүүдийг актлахыг зөвшөөрсүгэй.
2. Тогтоолын хавсралтад заасан хөрөнгүүдийн зохих журмын дагуу акталж, компанийн үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасахыг Гүйцэтгэх захирал Ч.Үржинбадам, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



А.ШАГДАРСҮРЭН









2022 оны 12 дугаар  
сарын 16 -ны өдөр

№: 22/20

Улаанбаатар  
хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын  
хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.9 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хөвсгөл усан зам” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Үржинбадамын үндсэн цалинг 4,600,000 /дөрвөн сая зургаан зуун мянга/ төгрөгөөр, гар утасны ярианы лимитийг 50,000 /тавин мянга/ төгрөгөөр, унааны лимитийг 500,000 /таван зуун мянга/ төгрөгөөр тус тус тогтоосугай.
2. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасан цалин, урамшууллыг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд мөрдсүгэй.
3. Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллыг тогтоосон хэмжээгээр тооцон олгохыг Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ, Тооцооны нягтлан бодогч Ж.Пүрэвжаргал нарт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



А.ШАГДАРСҮРЭН



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

**Авто тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл усан зам” ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дуусаж явах боломжгүй болсон, 1519 ХӨА улсын дугаартай, 00040021198827 арлын дугаартай, ОХУ-д үйлдвэрлэгдсэн ГАЗ-53 маркийн автомашиныг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Авто тээврийн үндэсний төвийн бүртгэлээс хасуулсан Гүйцэтгэх захирлын шийдвэрийг дэмжин баталгаажуулсугай.
2. Тээврийн хэрэгслийн бүртгэлээс хасагдсан автомашины татвар, хураамж ногдуулалт, бүртгэлийн асуудалд хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ, Тооцооны нягтлан бодогч Ж.Пүрэвжаргал нарт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



А.ШАГДАРСҮРЭН

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

**Зээл авах зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл усан зам” ХК-ийн хэлбэрийг өөрчилж, хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг санхүүжүүлэх зорилгоор “Булл Капитал” ББСБ (РД: 5787653)-аас 3 хувиас хэтрүүлэхгүй хүүтэй, 3-6 сарын хугацаатай, 204,025,000 /хоёр зуун дөрвөн сая хорин таван мянга/ төгрөгийн шугамын зээл авахыг зөвшөөрсүгэй.
2. Зээлдүүлэгчтэй зээлийн гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Ч.Үржинбадам/-д олгосугай.
3. Зээлийг шаардлагатай үед нь зээлдүүлэгчээс хэсэгчлэн авч зарцуулах, зээлдүүлэгч болон авсан зээлийн талаарх мэдээлэл, зээлийн зарцуулалтын талаар ТУЗ-д тайлагнахыг Гүйцэтгэх захирал болон Нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



А.ШАГДАРСҮРЭН